

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2020 оны 100 дугаар тушаалын  
7 дугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэл хувь	ХШҮ
Нэг	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ-2: ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ, ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО НЭМЭГДСЭН БАЙНА</b>							
	Гүйцэтгэлийн зорилт 2.2.1 Хяналт, үнэлгээ, мониторинг, тандалт судалгааны үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, болон шинжээчдийн оролцоог нэмэгдүүлэх	Улсын төсөв	Хамтран ажилласан болон дэмжлэг үзүүлсэн тоогоор	-	3	“Хөгжлийн бодлогын үнэлгээний чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны харьяа Хөгжлийн үнэлгээний байгууллага хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн арга хэмжээнд, дэмжлэг үзүүлж ажилласан.		
1	2.2.1.1 Хяналт, үнэлгээ, мониторинг, тандалт судалгааны үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж ажиллах	Улсын төсөв	Дэмжлэг үзүүлж ажилласан арга хэмжээний тоо	-	3	1.“Хөгжлийн бодлогын үнэлгээний чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны харьяа Хөгжлийн үнэлгээний байгууллага хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд 3 арга хэмжээ зохион байгууллаа. Үүнд: 1.2026 оны 02 сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах” бодлогын үнэлгээний Удирдах	100%	100

					<p>хорооны хурал, 2026 оны 02 сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Үнэлгээний удирдах хорооны хурал, 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан үнэлгээний стандарт боловсруулах ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>2. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/17 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 2026 оны 05 дугаар сарын 11, 12, 14, 15-ны өдрүүдэд "Төрийн бүтээмж-Эдийн засгийн өсөлт" сэдэвт нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, яам агентлаг, төрийн байгууллагуудын 85 албан хаагч, 21 аймгаас цахимаар 60 албан хаагч оролцсон.</p> <p>3. "Хөгжлийн бодлогын үнэлгээний чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны харьяа Хөгжлийн үнэлгээний байгууллага хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор "IV дэх удаагийн зуны үнэлгээний сургалт"-ыг 2026 оны 6 дугаар сарын 07-ны өдрөөс 6 дугаар сарын 11-ний өдрүүдэд, "2025 оны үнэлгээний чадавхын индекс"-ийн зөвлөлдөх уулзалтыг 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр тус тус зохион байгуулсан. Уг арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p>		
Гүйцэтгэлийн зорилт 2.2.2 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн бодит үр дүнг оролцогч талуудын үнэлгээгээр тооцох	Улсын төсөв	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн	-	95	Тайлант хугацаанд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт нийт иргэн, аж ахуйн нэгжээс 268 өргөдөл (1393 хуудастай) ирсэн байна. Үүнээс Хариутай 239, хариугүй 29 байсан ба	100%	90

			(хувь)			бүрэн шийдвэрлэсэн 189, хяналтад байгаа 46, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 3 өргөдөл байна. Шийдвэрлэлтийн хувь 79.08%		
2	2.2.2.1 Албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, тайлагнах	Улсын төсөв	Хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл гомдол (хувь)	-	95	Тайлант хугацаанд байгууллагын албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны асуудалтай холбоотой нийт 45 өргөдөл, хүсэлт ирснийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэж ажилласан байна.		90
Хоёр	<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4. МЭДЛЭГ, ИННОВАЦИ, ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН БАЙГУУЛЛАГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА</b>							
	Гүйцэтгэлийн зорилт 4.3.1 Байгууллагад эерэг, бүтээлч, ногоон дадал бүхий соёлыг төлөвшүүлэх	Улсын төсөв	Хэрэгжилтээр Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж	90	100	Албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэх ажлын байран дахь сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгоор хувь хүний хөгжлийн чиглэлээр сургалт, уулзалтуудыг цаг хугацааны давтамжтайгаар зохион байгуулан ажиллаж байна.	100%	
3	4.3.1.1 Байгууллагын ажлын орчны эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах "5S хөтөлбөр"-ийг эхлүүлэх	Улсын төсөв	Ажлын хэсгийн тушаал, Ажлын төлөвлөгөөний төсөл Тоо	1	1	Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй болон Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах 5S аргачлал сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад "Менежмент ба Ур чадварын хүрээлэн" ТББ-тай хамтран зохион байгууллаа. Тус сургалтад Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын нийт ажилтан, албан хаагчид оролцож •Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй •Ажлын байрны эмх цэгц, ажлын бүтээмжийг 5S аргачлалаар дээшлүүлэх онол болон практик хосолсон мэдлэг олгож, зөвлөмж хүргэлээ.	100%	50%
			Албан хаагчдад зориулсан сургалт (тоо)	1	1	2026/05/21-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яамны хурлын танхимд "Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйн сургалт" болон "Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах 5S аргачлал" сургалтыг Менежмент ба Ур чадварын		

						хүрээлэнтэй хамтран зохион байгуулж нийт 80 албан хаагч хамрагдав.		
4	4.3.1.2 Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Сайн саналын хөтөлбөр"-ийн төсөл боловсруулах	Улсын төсөв	Сайн саналын хөтөлбөрийн төсөл (тоо)	1	1	Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн сайн саналын хөтөлбөрийг боловсруулах тул хугацаа болоогүй	ХБ	ХБ
5	4.3.1.3 Албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийн судалгаа хийх, дүнг удирдлагад танилцуулах, холбогдох арга хэмжээг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Судалгааны тайлан (тоо)	1	1	Тандалт судалгаа бодлого төлөвлөлтийн газрын зохион байгуулсан Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгааны удирдамж, санал асуулгад санал өгч хамтран ажилласан. Тамгын газраас зохион байгуулах Албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгааг 2026 оны 3 дугаар улиралд зохион байгуулна.	ХБ	ХБ
6	Мэдлэг, инновац, технологид суурилсан сайн туршлага/арга хэмжээг байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Улсын төсөв	Арга хэмжээний тоо	-	1	Мэдлэг, инновац, технологид суурилсан сайн туршлага, арга хэмжээг байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр байгууллагын үйл ажиллагаанд цахим технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн байгууллагад цахимаар албан бичиг хүргүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдын ажлын цагийн уян хатан байдлыг Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/156 дугаар тушаалаар баталсан албан хаагчдыг цахимаар ажиллуулах журмын хэрэгжилтийг хангаж, нэгж бүрийн цахимаар ажиллах хуваарийг удирдлагаар нь баталгаажуулан Тамгын газарт төвлөрүүлж, цахим орчинд цагийн бүртгэл хийх, гүйцэтгэлийг хянах, ажлын тайланг нэгтгэн боловсруулах ажлыг тогтмолжуулсан. Ингэснээр ажлын байрны байршлаас үл хамааран төрийн албан хаагчдын ажлын тасралтгүй ажиллагааг хангах, мэдээлэл	100 %	0

						<p>солилцох үйл явцыг цахимжуулах, ажлын үр дүнг бодит мэдээлэлд үндэслэн хянах нөхцөл бүрдсэн.</p> <p>Мөн 2025 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 8.2-т заасан бага насны хүүхэдтэй албан хаагчдад ажил эхлэх болон тарах цагийн уян хатан зохицуулалтыг хүсэлтэд үндэслэн хэрэгжүүлж, хүний нөөцийн удирдлагад ажил, амьдралын тэнцвэрийг дэмжсэн орчин үеийн менежментийн арга барилыг нэвтрүүлэн ажилласан. Энэхүү зохицуулалт нь албан хаагчдын сэтгэл ханамж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүний нөөцийн бодлогыг уян хатан, үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэх сайн туршлагыг төлөвшүүлэхэд чиглэж байна.</p> <p>Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр байгууллагын дотоод үйл ажиллагаанд цахим ажлын зохион байгуулалт, уян хатан хөдөлмөр эрхлэлтийн менежмент зэрэг инновац, технологид суурилсан шийдлүүдийг нэвтрүүлж, ажлын бүтээмж, шуурхай байдал, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан.</p>		
<p><b>Гүйцэтгэлийн зорилт 4.3.2 Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг дээшлүүлэх</b></p>		Улсын төсөв	<p><b>Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь)</b></p>	90	100	<p>-Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 11 албан хаагчид (давхардсан тоогоор) 10,5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийн өөрийн хүсэлтийг үнлэслэн олгосон, 14 албан хаагчид цалинтай чөлөө, 1 албан хаагчид цалингүй чөлөө, 2 албан хаагчдад хүүхэд асрах чөлөө, 1 албан хаагчийн биеийн эрүүл мэндийг харгалзан цахимаар ажиллуулах зохицуулалтыг хийж ажилласан байна.</p>	100%	20
7	<p><b>4.3.2.1</b> Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах</p>	Улсын төсөв	<p>Төлөвлөгөөний хэрэгжилт (хувь)</p>	90	90	<p>2026 оны Нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.</p> <p>2026 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 11 албан хаагчид 10,5</p>		

						<p>сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгох, 14 албан хаагчид цалинтай чөлөө, 1 албан хаагчид цалингүй чөлөө олгох, 2 албан хаагчдад хүүхэд асрах чөлөө, 1 албан хаагчийн биеийн эрүүл мэндийг харгалзан цахимаар ажиллах тушаалын төслийг боловсруулан, эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ажиллав.</p> <p>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт үр бүтээлтэй ажилласан 4 албан хаагчийг төрийн дээд одон медалиар шагнуулах ажлыг зохион байгууллаа.</p> <p>Албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношлогоог эрүүл мэндийн 3 дугаар шатлалын эмнэлэгт үзүүлэх, хэвтэн эмчлүүлэх талаар Улсын төв 2-р эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.</p>		20
<p><b>Гүйцэтгэлийн зорилт 4.3.3. ISO9001:2015 Олон улсын чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлэх</b></p>		Улсын төсөв	Бэлтгэл ажлын төлөвлөгөөний төсөл (Тийм-1 Үгүй-0)	1	1	<p><b>Энэхүү ажлыг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах төсвийг байгууллагын 2026 он төсөвт тусгуулсан.</b></p>		
8	<p><b>4.3.3.1. Стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг судлах, холбогдох зардлыг 2026 оны төсөвт суулгах</b></p>	Улсын төсөв	Төсөвт санал өгсөн эсэх (Тийм-1 Үгүй-0)	1	1 1	<p>2026 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Олон улсын чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо нэвтрүүлэх" зорилтын хүрээнд ISO 9001:2015 чанарын менежментийн стандартын баталгаажуулалт хийх зөвлөх үйлчилгээ авах 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг байгууллагын 2026 оны төсөвт суулгасан. Худалдан авалтыг 2026 оны 3 дугаар улиралд зохион байгуулна.</p>	95%	80

Гүйцэтгэлийн зорилт 4.3.4 Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг урт болон дунд хугацааны зорилго, зорилттой уялдуулан өргөжүүлэх		Улсын төсөв	Хамтын ажиллагаа бий болгосон гадаад, дотоод байгууллагы н тоо	3	3	Хэвлэл мэдээлэл, цахим мэдээллийн сангийн шинэчлэл, олон нийтэд мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлсэн.	100 %	
9	4.3.4.1 Иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг бүртгэж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, гэрээг дүгнэх	Улсын төсөв	Батлагдсан гэрээний тоо	99	100	Иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан нийт 10 гэрээний төслийн эрх зүйн үндэслэл хянав.	100%	50
10	4.3.4.2 Байгууллагын удирдлагыг цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах	Улсын төсөв	Мэдээллийн давтамж, (хувь)	80	90	Төрийн болон хувийн хэвшил, Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос ирүүлсэн санал, мэдээ, мэдээллийг байгууллагын удирдлагад тухай бүр танилцуулан, чиглэл авч хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.	100%	50
11	4.3.4.3 Байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд мэргэшлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	Улсын төсөв	Үзүүлсэн дэмжлэг, зохион байгуулсан арга хэмжээ (хувь)	80	90	Үндсэн чиг үүргийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор зохион байгуулж буй арга хэмжээний зохион байгуулалтыг хийх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газраас зохин байгуулсан 5 удаагийн уулзалтыг зохион байгуулж ажилласан байна. Үнэлгээ, мониторингийн газрын олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, уулзалтын 2 удаагийн арга хэмжээг зохион байгууллаа.		70

12	4.3.4.4 Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын тамгын газартай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааг хариуцах	Улсын төсөв	Хамтран ажилласан тоо	4	4	<p>Батлан хамгаалахын яам, Зэвсэгт хүчний жанжин штабтай хамтран байгууллагын албан хаагчдад Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаатай танилцах, цэргийн сургалт бэлтгэлийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2026.01.23-ны өдөр Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн байранд байгууллагын 120 албан хаагчийг хамруулан зохион байгуулан ажилласан.</p> <p>Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Төрийн тусгай хамгаалалтын газар, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газартай Засгийн газрын II дугаар байрны засвар, үйлчилгээ, ашиглалт, хамгаалалтын асуудлаар хамтран ажиллаж, 2 удаагийн уулзалтыг зохион байгуулан хуралдсан.</p> <p>Нийслэлийн ИТХ, "Улаанбаатар хөгжлийн корпорац"-тай хамтран байгууллагын гаднах авто зогсоолд нэвтрэх 9 зогсоолын эрхийг авч байгууллагын нэгж бүрд 1 эрх өгч зохион байгуулан ажилласан.</p>	100%	70
13	4.3.4.5 Төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах	Улсын төсөв	Хамтран ажиллах санамж бичиг, гэрээ (тоо)	3	5	<p>Төв Ази болон Пакистан Улсын Үнэлгээ болон үр дүнгийн сургалтын төвтэй хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны шинжилгээний (MESA) чиглэлээр хамтран ажиллах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл, хамтран ажиллах саналын төслийг тус тус боловсруулж хүргүүлсэн.</li> <li>- Засгийн газрын 2025 оны 01 сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэлгээ хийх журам", "Хяналт шинжилгээ хийх журам"-ыг тус тус англи хэлнээ орчуулж хүргүүлсэн.</li> </ul> <p>Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Төр-хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хууль тогтоомж,</p>	95%	70

						дүрэм, журмыг төр, хувийн хэвшлийн байгууллага болон иргэдэд сурталчлан таниулах, харилцан мэдээлэл солилцох, цахим шилжилт, цахимжуулалтыг сайжруулан хөгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн үр ашгийг дээшлүүлэхэд хамтран ажиллах зорилгоор Мэдээллийн Технологийн Нэгдсэн Холбоо (МИТА) ТББ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж хэрэгжилтийг хангах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулсан.		
14	4.3.4.6 Гадаад улс, олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах	Улсын төсөв	Хамтран ажиллах санамж бичиг, гэрээ (тоо)	1	2	"Төв Ази ба Пакистаны Үнэлгээ, үр дүнгийн судалгааны төв" (Center for Learning on Evaluation and Results for Pakistan and Central Asia – CLEAR PCA)-тэй хамтран ажиллах зорилгоор санамж бичгийн төсөл боловсруулж Үнэлгээ, мониторингийн газарт санал авахаар хүргүүлсэн.		50
Гүйцэтгэлийн зорилт 4.3.6 Байгууллагын удирдлагын мэдээллийн системийн үр ашиг, аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах		Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь)	100	100	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар (ags.gov.mn) цахим хуудсанд байгууллагын ил тод байдал, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн стратеги, байгууллагын үйл ажиллагааны тайлан, албан хаагчдын мэдээлэл болон цаг үеийн мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллалаа.	100%	100
15	4.3.6.1 Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын фэйсбүүк Пэйж хуудас, Вэб сайт дахь мэдээллийг шинэчлэх, байнгын ажиллагааг хангах	Улсын төсөв	Вэб сайтад байршуулсан мэдээний тоо	150	200	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын веб сайт болох www.ags.gov.mn сайтад байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой нийт 30 мэдээ мэдээлэл оруулж ажиллалаа.		

						<p>Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын албан ёсны пэйж хуудсанд 70 гаруй мэдээлэл нийтэлж ажилласан.</p> <p>Үүнд: Видео 30, фото зураг текст, инфографик бүхий мэдээлэл 40 багтсан бөгөөд байгууллага дээр болж буй олон нийтэд түгээх шинжтэй бүхий л үйл ажиллагаа, хяналт шалгалтын тайлан мэдээлэл, инфографик, уулзалт, сургалтын мэдээллүүд багтсан болно.</p> <p>И-Монголиа дахь төрийн мэдээллийн нэгдсэн сангийн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын албан ёсны хуудсанд нийт 23 мэдээлэл байршууллаа. (Үүнд: Видео мэдээ 2, фото мэдээ 3, текстэн мэдээлэл 18)</p> <p>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газраас зохион байгуулсан иргэдийн болон төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хийсэн судалгаа зэрэг 2025 онд хийсэн судалгааны тайлангуудаас 20 орчим мэдээллийг боловсруулж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын албан ёсны пэйж хуудсаар цуврал инфографик мэдээллийг олон нийтэд түгээж ажиллалаа.</p>		
16	<p><b>4.3.6.2</b> Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, сурталчлах, байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээлэлд хяналт тавих, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах</p>	Улсын төсөв	Хууль тогтоомжийн хүрээнд бодит мэдээллээр хангах (тоо)	40	50	<p>И-Монголиа дахь төрийн мэдээллийн нэгдсэн сангийн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын албан ёсны хуудсанд нийт 23 мэдээлэл байршууллаа. (Үүнд: Видео мэдээ 2, фото мэдээ 3, текстэн мэдээлэл 18) байршууллаа.</p> <p>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд 4 удаагийн салбаруудын уулзалтаас видео мэдээлэл бэлтгэж, олон нийтийн сүлжээнд түгээлээ.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Чөлөөль" санаачилгын хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын бизнесийн салбарынхантай хийсэн уулзалтууд, Туулын хурдны замын хяналт шалгалтын мэдээллийг</p>	100%	100

						<p>текст болон видео хэлбэрээр бэлтгэж, холбогдох холбоод болон www.ubn.mn, www.asu.mn, www.exit.mn, www.newspress.mn TV9 телевиз, www.gonews.mn www.shuud.mn www.tsahiur.mn зэрэг 10 орчим хэвлэлийн редакцияар дамжуулан мэдээлэл өглөө.</p> <p>•Эдийн засаг, хөгжлийн яамнаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын нээлттэй өдөрлөгийн хүрээнд нийт 5 видео мэдээ, 5 текстэн мэдээлэл бэлтгэж Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын пэйж хуудас, вэб сайтад байршуулан ажиллахаас гадна Монголын үндэсний радио телевизийн Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрөөр 2 удаа, Монголын үндэсний радиогоор 4 удаагийн шууд мэдээ, "Тэнгэр" телевизээр 2 мэдээ, 1 шууд ярилцлага, ТВ9 Телевизээр 2 мэдээ, Монгол HD Телевизээр 1 мэдээ, MN25 Телевизээр 2 мэдээ тус тус нэвтрүүлж ажиллалаа.</p>		
17	4.3.6.3 Хэвлэлийн хурал, хэлэлцүүлэг, уулзалтын мэдээг бэлтгэх	Улсын төсөв	Хууль тогтоомжийн хүрээнд бодит мэдээллээр хангах (тоо)	50	130	<p>НҮБ-ын зөвлөх, Азийн бүтээмжийн байгууллага, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээн дэх уулзалтууд зэргээс тогтмол мэдээ мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд шинэчлэн боловсруулж буй хуулийн талаар 3 видео, 2 богино хэмжээний дүрс бичлэг, 3 текст бэлтгэж түгээсэн.</p> <p>НҮБ, Азийн бүтээмжийн байгууллага зэрэг олон улсын байгууллагуудтай хийсэн уулзалтуудаас тогтмол мэдээ бэлтгэв</p> <p>•Төрийн хяналт шалгалтын хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга хийх 4 удаагийн танхимын уулзалтаас мэдээ, мэдээлэл, видео мэдээллийг тухай бүр бэлтгэн, олон нийтийн хүртээл болгон ажиллав.</p> <p>•Германы Хөгжлийн үнэлгээний хүрээлэн (DEval), Азийн хөгжлийн банк (ADB), Ази Номхон далайн бүсийн Үнэлгээний холбоо (APEA), НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF) болон бусад хамтын</p>	100%	100

						<p>ажиллагааны уулзалтуудаас мэдээлэл бэлтгэж, түгээж ажиллалаа.</p> <p>Төрийн байгууллага болон олон нийтийн байгууллагуудад чиглэсэн 80 орчим үйл ажиллагааг 2026 оны эхний хагас жилийн байдлаар зохион байгуулж ажилласан байна.</p> <p>2026 оны эхний хагас жилийн байдлаар олон улсын 6 байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, давхардсан тоогоор 12 орчим үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан.</p> <p>Дотоодын 4 төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн талаар мэдээ бэлтгэж 10 удаагийн хамтарсан үйл ажиллагаа зохион байгуулсан.</p> <p>Түүнчлэн бусад төрийн байгууллага болон олон нийтэд чиглэсэн 7 удаагийн сургалт, 22 удаагийн хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулсан байна.</p> <p>Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын албан ёсны Facebook хуудсанд 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл нийт 39 видео мэдээ байршуулсан байна. Үүнээс 8 видео мэдээ нь телевизэд өгсөн ярилцлага, 31 видео мэдээ нь олон нийтэд чиглэсэн мэдээлэл байна.</p> <p>Мөн хугацаанд олон нийтэд чиглэсэн нийт 150 удаагийн мэдээлэл оруулсан. Үүнд: судалгааны тайлан, хэлэлцүүлэг, уулзалт болон зурган мэдээлэл зэрэг багтаж байна.</p> <p>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (AGS) мэдээ, фото мэдээ, сургалт, хэлэлцүүлэг, хамтын ажиллагаа, нээлттэй өдөрлөг, судалгаа, тайланг багтаасан 37 мэдээ шинээр оруулсан.</p>		
18	4.3.6.4 Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг англи хэл болон монгол бичгээр цахим хуудсанд байршуулж гадаад дотоодод мэдээлэх	Улсын төсөв	Хууль тогтоомжийн хүрээнд бодит мэдээллээр хангах (тоо)	15	20	Байгууллагын <a href="http://www.ags.gov.mn">www.ags.gov.mn</a> албан ёсны цахим хуудсанд гадаад, дотоод үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдээс үндэсний бичгээр 3 мэдээ, англи хэл дээр 5 мэдээг тус тус нийтэлж, монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	80

Гурав		ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						
	Гүйцэтгэлийн зорилт 3.1 Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэх	Улсын төсөв	Төлөвлөгөөний биелэлт (хувь)	100	100	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Тэргүүн Шадар сайд бөгөөд, Эдийн засаг, хөгжлийн сайдаар батлуулан гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнан ажиллаж байна.	100%	
19	3.1.1 Байгууллагын болон газар, нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, батлуулах, тайлан нэгтгэл хийх	Улсын төсөв	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө	Төлөвлөгөө-1	Төлөвлөгөө-1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг <a href="https://pm.hrs.gov.mn/">https://pm.hrs.gov.mn/</a> системд орууллаа.	100%	70
			Байгууллагын нэгдсэн тайлан	Тайлан-2	Тайлан-2			
			Газар, нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан	Төлөвлөгөө-4 Тайлан-4	Төлөвлөгөө-4 Тайлан-4			
Гүйцэтгэлийн төлөвлөгөө	1	1						
20	3.1.2 Байгууллагын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Улсын төсөв	Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт (хувь)	85	90-ээс доошгүй	2026 оны сургалтын төлөвлөгөөнд 23 сургалт зохион байгуулахаар төлөвлөснөөс (Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтыг оруулсан.) бусад байгууллагатай хамтран 11 сургалтыг зохион байгуулж, Удирдлагын академийн Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын Тэргүүн түшмэлийн болон ахлах түшмэлийн багц сургалтад 5 албан хаагчийг хамруулж ажиллалаа. Албан хаагчдыг мэдлэг ур чадварыг сайжруулах зорилгоор Тайланд улсад "Дата анализ" сургалтад 1 албан хаагчийг хамрууллаа.	100%	80

						Байгууллагын дотоод нэгжийн нөөц ашиглан 2 сургалт зохион байгуулахаар төлөвлөснөөс Тандалт судалгаа бодлого төлөвлөлтийн газар “Эрсдэлийн удирдлагын журам, Хорооны дүрэм” хэрэгжүүлэхтэй холбоотой сургалтыг зохион байгуулсан. Төрийн байгууллагын захиалгаар 5 удаагийн сургалт, 18 удаагийн хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулаад байна.		
21	3.1.3 Төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Хуулийн хугацаанд зэрэг дэв олгогдсон албан хаагч (хувь)	100	100	Төрийн захиргааны албан тушаалын эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийн шаардлага хангасан 14 албан хаагчид зэрэг дэвийг олгуулах хүсэлтийн 2026 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01/95 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2026 оны 118 дугаар захирамжаар Төрийн захиргааны албан тушаалын эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг 6 албан хаагчид олгов. Төрийн албан тушаалын ахлах, дэс түшмэлийн ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин болон шаардлага хангасан нийт 37 албан хаагчид Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2026 оны Б/15, Б/53 дугаар тушаалаар ахлах түшмэлийн болон дэс түшмэлийн зэрэг дэвийг олгов.	100%	100

22	3.1.4 Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулах	Улсын төсөв	Батлагдсан АТТ (хувь)	100	100	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/125 дугаар тушаалаар баталсан Зохион байгуулалтын бүтцийн нэгжид өөрчлөлт оруулах тухай тушаалд өөрчлөлт оруулж, гэрээт албан хаагчийн орон тоог өөрчлөх албан шаардлага ирүүлсэн. Үндэсний аудитын газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 232/А0170039 САГ-2026/94/НА-СТА-ТШЗ дугаар албан шаардлагыг хэрэгжүүлж, гэрээт албан хаагчийн 9 орон тоог өөрчлөн, 2026 оны Б/48 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаал болгон өөрчилсөн. Өөрчлөлттэй холбоотойгоор Төрийн үйлчилгээний 9 ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, харьяа нэгжүүдийн саналыг тусгаж байна.	100%	100
23	3.1.5 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ, байгуулах, гэрээний биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Байгуулсан хөдөлмөрийн гэрээ (хувь)	100	100	Тайлант хугацаанд 12 гэрээт болон төрийн үйлчилгээний албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, 8 гэрээт ажилтны хөдөлмөрийн гэрээний хугацааг өөрийн хүсэлт болон гэрээний хэрэгжилтийг харгалзан дуусгавар болгосон.	100%	100
24	3.1.6 Байгууллагын сул орон тоог хуульд заасны дагуу нөхөх, Төрийн албаны сул орон тоо нөхөх тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулах	Улсын төсөв	Холбогдох хуулийн хэрэгжилт (хувь)  Тусгай шалгалт (тоо)	100 2	100 2	Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2 дэх хэсэгт заасны дагуу төрийн бусад байгууллага хооронд 22 албан хаагчийг шилжүүлэн болон сэлгүүлэн томилсон байна. Төрийн өөр байгууллагаас 10 албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх хэсэгт зааснаар шилжүүлэн ажиллуулж, төрийн албаны нөөцөд байгаа 4 иргэнээр, төрийн албан тухай хуулийн 44.3 дахь хэсэгт заасан хамгийн ойр 3 албан тушаалтнаар төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөхсөн байна. Мөн Төрийн үйлчилгээний 6 албан хаагчийг хөдөлмөрийн хугацаагүй гэрээний үндсэн дээр томилуулж ажилласан. Тамгын газрын ахлах нягтлан бодогчийн албан тушаалын сул орон тоо нөхөх сонгон шалгаруулалт зарлуулах хүсэлтийн 2026 оны 02	100%	100

						дугаар сарын 05-ны өдрийн 01/184 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны салбар зөвлөлд хүргүүлж 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр шалгалт зохион байгуулж, сул орон тоог нөхөж ажиллав.		
25	3.1.7 Албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангах	Улсын төсөв	Төрийн албан хаагчийн Хувийн хэрэг (хувь)	90	100	Албан хаагчдын хувийн хэргийн баяжилтийг тухай бүр хийж, нийт 128 албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 521 дүгээр тогтоолын хавсралтын дагуу хангуулан ажиллалаа.	100%	100
26	3.1.8 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнүүлэх ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Гүйцэтгэлийн үнэлгээ хийсэн тоо	4	4	Байгууллагын нийт 124 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хуулийн хугацаанд үнэлэх ажлыг зохион байгуулна. <a href="https://pm.hrs.gov.mn/">https://pm.hrs.gov.mn/</a> цахим системд албан хаагчийн оруулсан мэдээлэлд үндэслэн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлнэ.	100%	100
27	3.1.9 Байгууллагын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам боловсруулах	Улсын төсөв	Боловсруулсан дүрэм, журмын тоо	5	5	2026 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх 4 журмыг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> <li>• Эрсдэлийн удирдлагын журам, дүрэм батлах тухай 2026 оны А/11 дүгээр тушаалаар батлан үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллав.</li> <li>• Байгууллагын "Архив, албан хэрэг хөтлөлтийн журам-ыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2026.03.18-ны өдрийн А/24 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ талаар нийт албан хаагчдад сургалт зохион байгуулан ажиллав.</li> <li>• 2026 оны А/33 дугаар тушаалаар Тандалт судалгаа хийх аргачлал батлуулсан.</li> </ul>	100%	80

						<ul style="list-style-type: none"> <li>2026 оны А/57 дугаар тушаалаар Эцэг эхийн зөвлөлийн ажиллах журмыг батлуулсан.</li> </ul> <p>Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах чиглэлийг удирдлагаас өгсний дагуу саналыг боловсруулж байна.</p> <p>Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид өөрчлөлт орсон үед тухай бүр засвар, өөрчлөлт шинэчлэлтийн оруулан ажиллаж байна.</p>		
28	<b>3.1.10</b> Байгууллагын даргын тушаалаар батлах эрх зүйн акт, бусад шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянаж, хангуулах	Улсын төсөв	Хянасан эрх зүйн акт (хувь)	80	100	2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар 64 А тушаал, 107 Б тушаалын төслийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, баталгаажуулан ажиллав.	100%	<b>100</b>
29	<b>3.1.11</b> Монгол хэлний тухай хуулийн биелэлтийг хангуулж ажиллах	Улсын төсөв	Эх зохиогчийн орон тоо бий болгосон эсэх (Тийм-1 Үгүй-0)	1	1	Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагад эх зохиогчийн орон тоог бий болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагын даргын 3 албан тоот, 3 А тушаалыг үндэсний монгол бичигт хөрвүүлж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашигласан.	100%	<b>100</b>
			Байгууллагын албан бичгийг монгол бичгээр тогтмол үйлдэх (Тийм-1 Үгүй-0)	1	1	Мөн байгууллагын цахим хуудсанд байршуулсан 2 мэдээ, мэдээллийг үндэсний монгол бичигт хөрвүүлэн нийтэлж, монгол хэл, үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнээс гадна байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 12 албан бичгийг монгол бичгээр хөрвүүлж, төрийн албан хэрэг хөтлөлтөд Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. Ингэснээр байгууллагын дотоод болон гадаад харилцаанд үндэсний монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд үндэсний сурталчлан таниулах чиглэлээр тодорхой үр дүнд хүрсэн.	100%	<b>100</b>
<b>Гүйцэтгэлийн зорилт 3.2 Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг</b>		Улсын төсөв	<b>Хууль тогтоомжийн хэрэгжилт (хувь)</b>	90	<b>91-ээс доошгүй</b>	2025 оны ХАСХОМ-ыг байгууллагын нийт 69 албан хаагч бөглөн ажиллав. УИХ-ын 2024 оны 05 дугаар тогтоолын дагуу дэс түшмэлийн албан		

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах					тушаалын ХАСХОМ-ыг системээс хасаж мэдүүлсэн. Тайлант хугацаанд нийт 20 албан хаагчийн ХАСУМ-ыг шинэчилсэн системээр гаргаж АТГ-т хянуулсан болно.			
30	3.2.1 "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд Ёс зүйн хороо, байгууллагын Ёс зүйн дэд хороодтой хамтран ажиллах, үр дүнг тайлагнах	Улсын төсөв	Хэрэгжүүлсэн арга хэмжээ (тоо)	4	4	Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2024 оны "Журам, маягт, жагсаалт, шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын даргын 2024 оны А/96 дугаар тушаалаар баталсан "Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хоорондоо хэрэглээний зөрүүтэй байдал үүсгэж, албан хаагчдад хууль, журмыг нэг мөр ойлгож практик хэрэглээний талаар мэргэжил арга зүйн зөвлөмжийг Авилгатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж, нийт 68 албан хаагчдыг хамрууллаа. Ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан мөрдөн ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх, гарч болзошгүй эрсдэл, шалтгаан нөхцөлийг тодорхойлон холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороо 1 удаа хуралдаж, ирүүлсэн 1 гомдлыг холбогдох журмын дагуу хянан шийдвэрлэсэн. Мөн Тамгын газартай хамтран "Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүй", "Ажлын байрны эмх цэгцгийг сайжруулах 5S аргачлал" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академи, Канад-Монголын "MERIT" төслөөс хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш	100%	50%
			Ёс зүйн нөлөөллийн үйл ажиллагааны талаарх албан хаагчдын сэтгэл ханамж (хувь)	80	90			

						бэлтгэх нь" дунд шатны сургалтад манай байгууллагын ёс зүйн хорооны төлөөлөл хамрагдаж, ёс зүйт зан үйл, ёс зүйт шийдвэр гаргалт, хиймэл оюуныг ёс зүйтэй ашиглах, ёс зүйт манлайллын чиглэлээр мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн. Түүнчлэн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын дотоод журам, заавар, шаардлагатай мэдээллийг албан хаагчдад шуурхай хүргэх зорилгоор QR код бүхий мэдээллийн постер боловсруулж, шинээр ажилд орж буй албан хаагчдад тогтмол танилцуулан ажиллаж байна.		
31	3.2.2 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын жилийн төлөвлөгөө боловсруулан, Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах, үр дүнг тайлагнах	Улсын төсөв	Төлөвлөгөөний биелэлт (хувь)	90	90-ээс доошгүй	2025 оны ХАСХОМ-ыг байгууллагын 58 албан хаагч хуулийн хугацаанд тайлагнаж ажиллав. УИХ-ын 2024 оны 05 дугаар тогтоолын дагуу дэс түшмэлийн албан тушаалын ХАСХОМ-ыг системээс хасаж мэдүүллээ. Мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд шинэчлэлт хийсэнтэй холбогдуулан 2026 оны 01 сарын 01-ны өдрөөс байгууллагын Төрийн захиргааны албан хаагчдын мэдээллийг системд шинэчлэн ажиллав. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу байгууллагын албан хаагчдын 2025 оны ХАСХОМ-ын тайлангуудыг 2026 оны 02 сарын 26-ны өдрийн 01/150 дугаар албан бичгээр 5 багц тайланг хүргүүлээ.	100%	20%
Гүйцэтгэлийн зорилт 3.3 Урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнах		Улсын төсөв	Биелэлтийн хувь	90	100	Урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлагнан ажиллаж байна.		
32	3.3.1 Төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн шууд	Улсын төсөв	Хууль, тогтоомж,	70	100	Төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн шууд захирагчийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2029	100%	

	захирагчийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх		шийдвэрт нийцүүлэх (хувь)			оны төсвийн төсөөллийг нэгжүүдийн саналыг үндэслэн боловсруулж, төсвийн цагалбарын дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв.		100
33	3.3.2 Төсвийн шууд захирагчийн 2026 оны хуваарь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах	Улсын төсөв	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө биелэлт (хувь)	100	100	Төсвийн шууд захирагчийн 2026 оны төсвийн хуваарийг Төсвийн тухай хуулийн хугацаанд боловсруулан батлууллаа. 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгжийн дарга нарын саналыг үндэслэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2026 оны А/01, А15 тушаалаар тус тус батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.	100%	100
34	3.3.3 Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд гаргаж тайлагнах, холбогдох байгууллагад хүргүүлэх	Улсын төсөв	Тайлан, мэдээний тоо	4	4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох Санхүүгийн тайлан, мэдээг тайлагнан ажиллаж байна.	100%	100
35	3.3.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах	Улсын төсөв	Мэдээний тоо	171	171	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган, тайлант хугацаанд нийт мэдээлэх ёстой 171 мэдээллээс 67 мэдээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Мэдээлэх хугацаа болоогүй 104 мэдээг хуулийн хугацаанд мэдээлэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллана.	100%	100
36	3.3.5 Өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодох ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал, жилийн санхүүгийн тайланд тэнцэлд тусгах	Улсын төсөв	Бүртгэл хийсэн байдал (тоо)	4	2	Байгууллагын өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийж, тооцоо бодох ажлыг зохион байгуулан, үр дүнг улирал, жилийн санхүүгийн тайлан тэнцэлд тусган ажиллаж байна. Байгууллагын нийт эд хөрөнгийн 2026 оны хагас жилийн болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны нэгдсэн тооллогыг 6 сарын 10-ны өдрөөс 6 сарын 25-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэн үр дүнг тайлагнахаар ажиллаж эхлээд байна.	100%	100

	<b>Гүйцэтгэлийн зорилт 3.4 Байгууллагын архив, албан хэргийг хөтлөх, дотоод үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих</b>	Улсын төсөв	<b>Биелэлтийн хувь</b>	<b>100</b>	<b>100</b>	Тайлант хугацаанд 431ш 2471 хуудас албан бичиг илгээсэн, 470ш 8351 хуудас албан бичиг хүлээн авсан, 118ш 591 хуудас өргөдөл, гомдол хүлээн авч бүртгэн 100% шилжүүлсэн. 2025 оны явсан бичгийн стандартын дагуу архивын нэгж үүсгэн 28 баримт 4087 хуудас материал 03 сарын 05-ны өдөр архивд хүлээлгэн өгсөн. 431албан бичиг, 72 тушаал, хавсралтын хамт стандартад нийцүүлэн хэвлэсэн мөн 13 томилолтын хуудсыг хэвлэсэн. Хэвлэмэл хуудас, дугуйн нөөц хангалттай байж албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа тасралтгүй явагдсан.	<b>100%</b>	
37	<b>3.4.1</b> Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Улсын төсөв	Журам батлагдсан эсэх (тоо)	1	1	Байгууллагын даргын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар "Архив, албан хэрэг хөтлөлтийн журам"-ыг батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%	<b>100</b>
38	<b>3.4.2</b> Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Жагсаалт батлах (тоо)	1	1	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын төслийг боловсруулж, удирдлагад танилцуулсан.	90%	<b>90</b>
39	<b>3.4.3</b> Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн индексийг шинэчлэн батлуулах, мөрдүүлж ажиллах	Улсын төсөв	Индекс батлах (тоо)	1	1	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн индексийг газрын даргын 2025 оны А/196 дугаар тушаалаар шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%	<b>100</b>
40	<b>3.4.4</b> Архивын зориулалтын өрөө, тасалгааг стандартад нийцүүлэн засвар хийх ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Гэрээ байгуулах (тоо)	1	1	ЗГХХГ-ын даргын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/65 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Засгийн газрын барилгын нэгдүгээр давхарт байрлах архивын өрөө болон ЗГБНҮГ-ын өрөө тасалгаанд засвар хийх ажлыг зохион байгуулж байна. Сонгон шалгаруулалтаар шалгарсан "Өнших" ХХК засварын ажлыг эхлүүлж, ажлын явцад хяналт тавин ажиллаж байна. Засварын ажил бүрэн дууссаны дараа архивын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор архивын тоног төхөөрөмж нийлүүлж, нягтруулсан шүүгээ суурилуулсан "Грандмакс" ХХК-аар архивын сан хөмрөгийг Засгийн газрын II	90%	<b>50%</b>

						байрны Г корпусаас Б корпус руу нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна.		
41	3.4.5 Байгууллагад ирсэн албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэн, шилжүүлэх, харилцсан бичгийг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөх	Улсын төсөв	Бүртгэсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо	2329	2500	Тайлант хугацаанд 668ш 4695 хуудас албан бичиг илгээсэн. 883ш 13557 хуудас албан бичиг хүлээн авсан. 268ш 1393 хуудас өргөдөл, гомдол хүлээн авч бүртгэн 100% шилжүүлсэн. 2025 оны явсан бичгийн стандартын дагуу архивын нэгж үүсгэн 28 баримт 4087 хуудас материал 03 сарын 05-ны өдөр архивд хүлээлгэн өгсөн. 668 албан бичиг, 172 тушаал, хавсралтын хамт стандартад нийцүүлэн хэвлэсэн мөн 23 томилолтын хуудсыг хэвлэсэн. Хэвлэмэл хуудас, дугтуйн нөөц хангалттай байж албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа тасралтгүй явагдсан.	100%	100
42	3.4.6 Байгууллагын архивын үйл ажиллагааг холбогдох хууль, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулах	Улсын төсөв	Хууль тогтоомжийн хэрэгжилт (хувь)	100	100	Байгууллагын архивд нэгжүүдээс баримт хүлээн авах хуваарийн дагуу 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 404 хадгаламжийн нэгжийг архивд хүлээн аваад байна.	100%	100%
43	3.4.7 Албан хаагчдын өрөө, тасалгааны тохижилт, аюулгүй байдлыг хангах	Улсын төсөв	Мэдээллээр шуурхай хангасан байх, үйл ажиллагаа хэвийн явагдах (хувь)	100	100	Албан хаагчдын өрөө, тасалгааны тохижилт, аюулгүй байдалд тухай бүр анхаарч, шаардлагатай засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулан ажилласан.	100%	50
44	3.4.8 Нийт албан хаагчдад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр албан хаагчдын дунд сургалт зохион байгуулах	Улсын төсөв	Зохион байгуулагдсан сургалт (тоо)	1	2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр албан хаагчдын дунд Сургалтыг гуравдугаар улиралд багтааж хийхээр тохиролцсон.		ХБ
45	3.4.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ, шаардлагад нийцсэн дэд бүтэц бүрдүүлэх судалгаа хийх	Улсын төсөв	Судалгааны тайлан (тоо)	1	1	Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын Засгийн газрын байрнуудын нэгдсэн захиргааны дэмжлэгтэйгээр Засгийн газрын II байрны "Б" хэсгийн гадна нэвтрэх хаалганд хөгжлийн	100%	100%

						бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу шатыг хийж байршуулсан.		
46	3.4.10 Гадаад, дотоод томилолтоор ажиллах албан хаагчдад өгөх аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж боловсруулж, батлуулах	Улсын төсөв	Зөвлөмж батлагдсан эсэх (Тийм-1, Үгүй-0)	1	1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс баталсан гадаад, дотоод томилолтоор ажиллах үеийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмжийг нийт 69 албан хаагчид танилцуулж, зааварчилгаа өгч, гарын үсгээр баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100%	100%
47	3.4.11 "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө" боловсруулан батлуулах, албан хаагчдад танилцуулах	Улсын төсөв	Төлөвлөгөө батлагдаж, албан хаагчдад танилцуулагдсан байна (Тийм-1, Үгүй-0)	1	1	Онцгой байдлын ерөнхий газарт Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г батлуулан хүргүүлж, мөрдлөг болгон ажиллаж байна.	100%	50%
48	3.4.12 Зөвлөл, хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, арга зүйгээр хангах (Даргын зөвлөл, Ёс зүйн, спорт, өмч хамгаалал гэх мэт)	Улсын төсөв	Хийгдсэн уулзалт, хурал (тоо)	5	5	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2026.05.28-ны өдрийн Эцэг, эхийн зөвлөл байгуулах тухай А/57 дугаар тушаалыг албажуулсан. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дэргэдэх Даргын зөвлөлийн 11 хуралд дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн оролцож, хурлын тэмдэглэл хөтөлсөн байна. Тайлант хугацаанд ХАБЭА-н зөвлөлөөс баталсан гадаад, дотоод томилолтоор ажиллах үеийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмжийг нийт 69 албан хаагчид танилцуулж, мөрдөж ажиллах талаар зааварчилгаа өгч, гарын үсгээр баталгаажуулсан. Энэхүү арга хэмжээ нь томилолтын үед учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын аюулгүй ажиллагааны мэдлэг, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор зөвлөлийн ажиллах журмын төслийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн боловсруулж, Хууль эрх зүйн газарт	100%	50%

						хүргүүлэн хянуулж, санал авах шатанд ажиллаж байна. Албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран сургалт зохион байгуулахаар тохиролцож, 2026 оны гуравдугаар улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна.		
	<b>Гүйцэтгэлийн зорилт 3.5 Байгууллагын дотоод үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, хурал, уулзалтыг зохион байгуулалтаар хангаж ажиллах</b>	Улсын төсөв	<b>Биелэлтийн хувь</b>	-	100%	<b>Цаг үеийн шинжтэй, шуурхай зохицуулалт шаардсан ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.</b>	100%	
49	3.5.1 Цаг үеийн шинжтэй, шуурхай зохицуулалт шаардсан ажил, арга хэмжээг зохион байгуулах, бусад нэгжийн зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв	Ажил, арга хэмжээний тоо (Гүйцэтгэлээр)	21	21	"Төрийн бүтээмж-Эдийн засгийн өсөлт" сэдэвт нээлттэй өдөрлөгийг 2026.05.11-15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Үнэлгээчдийн олон улсын сургалтын арга хэмжээнд 2026.06.07-11-ны өдрүүдэд дэмжлэг үзүүлж ажилласан. 2026.05.29-ны өдөр зохион байгуулагдсан "Төрийн байгууллагуудын мэдээлэл, лавлагааны 1800XXXX тусгай дугаарын ашиглалтын өнөөгийн байдал, сайжруулах шийдэл" сэдэвт хэлэлцүүлгийн зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажилласан.	50%	50%
50	3.5.2 Даргын зөвлөлийн хурал зохион байгуулж, албажуулах	Улсын төсөв	Албажуулсан хурлын тэмдэглэл (тоо)	22	25	Даргын зөвлөлийн 11 удаагийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, тэмдэглэл хөтөлж албажуулав.	92%	92%
51	3.5.3 Нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт тавих, байгууллагын орчны цэвэрлэгээ, тохижилт үйлчилгээ, аюулгүй байдал, дотор цэвэрлэгээ үйлчилгээ, тог цахилгаан,	Улсын төсөв	Гэрээний биелэлт (хувь)	90	91%-иас доошгүй	Албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, цэвэрлэгээ, тохижилт, тог цахилгааны асуудал, аж ахуйн бусад асуудлыг тухай бүр Нийтлэг үйлчилгээний газрын эрх бүхий хаагчтай хамтран тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Ажлын байранд тухай бүр засварын ажлыг ЗГБНУГ-ын албан хаагчдаар гүйцэтгүүлж, албан	100%	70%

	аж ахуйн бусад асуудлыг хэвийн үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх					хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан ажиллаж байна.		
52	3.5.4 Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журмын дагуу хэрэгжүүлэх	Улсын төсөв	Заавар, журам, стандартын шаардлагыг хангах (тоо)	4	4	Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр зохион байгуулалтын нэгж, албан хаагчдад зааварчилгаа өгч, архивын баримт бүрдүүлэх талаар ажлын байран дээр арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэн ажиллаж байна. ABLE-Олон нийтийн-Зар мэдээ, масс мессежээр архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр тогтмол заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна. Байгууллагын даргын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар "Архив, албан хэрэг хөтлөлтийн журам"-ыг батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%	100
53	3.5.5 Холбогдох бусад ажил, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	Улсын төсөв	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	4	4	1. Байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд дараах албан байгууллагуудтай хамтарч ажиллах гэрээг байгууллаа. 1. 1.Практикал даатгал ХХК-Тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ. 2. 2.Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-Дулаан зогсоолын гэрээ 3. 3.Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-Тээврийн хэрэгслийн засварын гэрээ 4. 4.Петровис ХХК-Картын зээлийн гэрээ 2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тогтоолоор шилжүүлэн авсан 3 ширхэг газрын гэрчилгээг байгууллагын нэр дээр гаргуулсан.  3.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу акталж данс бүртгэлээс хасах 188 ширхэг 104,6 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг актлуулж данс бүртгэлээс хасуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026.05.12-ны өдрийн А1/899 тоот албан бичгийн дагуу акталж данснаас хассан 187	100%	70%

					ширхэг хөрөнгийг Хил хамгаалах байгууллагад хүлээлгэн өгсөн.		
							78,0

ТАЙЛАНГ ҮНЭЛСЭН:  
 ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ  
 ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА

*[Signature]* ..... П.БАТБААТАР



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
 ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*[Signature]* ..... Р.ДЭЖИД

ТАЙЛАГНАСАН:  
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*[Signature]* ..... Ц.НАРАНЧИМЭГ